



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Э.ХОНГОРЗУЛ ТАНАА

2022. 10. 20 № 4/1408

танай _____ -ны № _____ -т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 9 дүгээр сарын 21-д тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг бүртгэл байхгүй, хяналтад авдаггүй. Байгууллагын болон мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг зөв тодорхойлоогүй. Тайлан, мэдээг үйл явцаар тоочиж биш үр дүнд суурилан суурь түвшинтэй харьцуулсан байдлаар товч тодорхой бичих тал дээр анхаарах шаардлагатай байна.

Зөвлөмж:

1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн холбогдох заалтуудыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захирагааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 10.7-д заасны дагуу хяналтад авч, жил бүр жагсаалтыг шинэчлэн агентлагийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах

2.Байгууллагын болон мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, суурь түвшинг товч тодорхой болгох

3.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хийхдээ нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс өөрийн хийх ажлыг арга хэмжээ болгон задалж оруулах

4.2022 оны жилийн эцсийн Сайдын гэрээний биелэлтийг гэрээнд заасан аймгийн Засаг даргын хүлээх үүрэг болон гэрээний хавсралтаар тус бүр гаргаж хугацаанд нь ирүүлэх

5.Хяналтын хуудасны журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тал дээр анхаарах

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж биелэлтийг 2022 оны 10дугаар сарын 28-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

